



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А794

Улаанбаатар хот

「Журам, тодорхойлолт, загвар батлах тухай」


Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг, “Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 1.2, 2.1, 2.4, Засгийн газрын 2018 оны 260 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын дипломат, албан паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын 2.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан “Хүндэт дипломат” хүндэт тэмдгээр шагнах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хүндэт дипломат” хүндэт тэмдгийн тодорхойлолт болон үнэмлэхийн загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

САЙД



Д.ЦОГТБААТАР



Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан
"Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр шагнах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 2.2, 2 дугаар хавсралтаар баталсан "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ын 36-д заасан Засгийн газрын салбарын тэргүүний ажилтны "Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр шагнуулахаар нэр дэвшүүлэх, тодорхойлох, шагнал олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

Хоёр. Шагналд нэр дэвшүүлэх болзол

2.1 Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд бататгах, Монгол Улсын гадаад харилцааг хөгжүүлэх, төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх, төрийн болон дипломат алба, хууль ёсыг бэхжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан төрийн албан хаагч, гадаад харилцааны салбарт ажиллаж байсан ахмад дипломатч, Монгол Улсын бусад иргэнийг Засгийн газрын салбарын тэргүүний ажилтны "Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр шагнуулахаар нэр дэвшүүлнэ.

2.2 Албан хаагчийг нэр дэвшүүлэхдээ ажлын үр дүн нь өмнөх түвшингээс ахисан, сахилгын болон ёс зүйн зөрчилгүй, өмнөх шагнал (байгууллагын болон Засгийн газрын шагнал)-аас хойш 3-аас доошгүй жил ажилласан, төрийн албанд 12-оос доошгүй жил идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажилласан байх болзлыг баримтална.

2.3 Төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацааг нь харгалзахгүйгээр нэр дэвшүүлж болно.

Гурав. Шагналд тодорхойлох

3.1 Энэ журамд заасан болзлыг хангасан төрийн албан хаагч, Монгол Улсын бусад иргэдийг "Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр шагнуулахаар Гадаад харилцааны яам (цаашид "Яам" гэх)-ны газар, нэгж, хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газар (цаашид "ДТГ" гэх) болон бусад төрийн болон төрийн бус байгууллагаас нэр дэвшүүлэхдээ дараахь баримт бичгийг бүрдүүлэн яамны Төрийн захиргааны удирдлагын газар (цаашид "ТЗУГ" гэх)-т ирүүлнэ:

3.1.1. Гадаад харилцааны сайдын тушаалаар баталсан загварын анкет

3.1.2 яамны газар, нэгж, ДТГ-ын болон бусад төрийн болон төрийн бус байгууллагын хамт олны хурлын тэмдэглэл;

3.1.3 төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлснийг гэрчлэх баримт бичиг, нотолгооны хуулбар

3.1.4 яамны газар, нэгж, ДТГ-ын болон холбогдох бусад байгууллагын удирдлагын гарын үсэг бүхий ажил байдлын тодорхойлолт

Дөрөв. Шагнал олгох

4.1 Төрийн захиргааны удирдлагын газар холбогдох материалыг хянаж, "Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр шагнуулах асуудлыг Гадаад харилцааны сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

4.2 "Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр Үндэсний их баяр наадам, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний өдөр буюу 12 дугаар сарын 29, Ахмадын өдөр зэрэг **нийтээр тэмдэглэх бусад тэмдэглэлт өдөр**, холбогдох төрийн байгууллагын тэгш ойг тохиолдуулан шагнана.

4.3 Энэ журмын 4.2-т заасан баярын болон тэмдэглэлт өдрийг тохиолдуулан нэг удаа 2-оос илүүгүй хүнийг "Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр шагнана.


4.3 "Хүндэт дипломат" хүндэт тэмдгийг Гадаад харилцааны сайдын тушаалаар олгох бөгөөд Гадаад харилцааны сайд яамны газар, нэгжүүдийн удирдлага болон хамт олны өмнө хүндэтгэлтэйгээр гардуулна.

Тав. Бусад зүйл

5.1 "Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр шагнагдсан албан хаагч болон ахмад дипломатчид Гадаад харилцааны сайдын зөвшөөрлөөр дипломат паспорт олгож болно.

5.2 ТЗУГ "Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр шагнагдсан албан хаагчдын болон бусад хүний мэдээллийн санг хөтөлнө.

5.3. Төрийн албан хаагч "Хүндэт дипломат" хүндэт тэмдгээр шагнагдсан тухай шийдвэр, холбогдох бусад материалыг Төрийн албаны тухай хуулийн 15.1-д заасны дагуу албан хаагчийн хувийн хэрэгт хадгална.



Гадаад харилцааны сайдын
2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн
19/11 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

1. “Хүндэт дипломат” хүндэт тэмдгийн тодорхойлолт

“Хүндэт дипломат” хүндэт тэмдэг нь гонзгой дугуй хэлбэртэй, алтан шар өнгөтэй лаврын навчаар хүрээлсэн, дунд хэсэг нь дэлхийн бөмбөрцгийн дүрстэй цэнхэр суурин дээр соёмбо дүрсэлж, соёмбын доор бадамлянхуа цэцэг байрлуулж, түүний доод талд “Хүндэт дипломат” гэсэн үгийг монгол үсгээр бичсэн байна. Тэмдгийн урт нь 40-45 мм, өргөн нь 20-22 мм, зузаан нь 2.5 мм-ээс илүүгүй хэмжээтэй байна.

2. “Хүндэт дипломат” хүндэт тэмдгийн үнэмлэхийн загвар:

“Хүндэт дипломат” тэмдэг нь хувийн дугаартай, Гадаад харилцааны сайдын гарын үсэг бүхий үнэмлэхтэй байх бөгөөд үнэмлэхэд “.....Таны Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд бататгах, Монгол Улсын гадаад харилцааг хөгжүүлэх, төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх үйлст оруулсан хувь нэмрийг үнэлж, Таныг Засгийн газрын салбарын тэргүүний ажилтны “Хүндэт дипломат” хүндэт тэмдгээр шагнав” гэсэн бичвэртэй байна.
